



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/18

Алтрага

Мод бэлтгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын менежмент төлөвлөгөө болон сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, ойн нөхөрлөлүүдэд хуваарилагдсан хэрэглээний болон түлшний мод бэлтгэх зөвшөөрлийг олгосугай.

2.Арчилгаа, цэвэрлэгээний огтлолд цэвэрлэгээний ажлаар бэлтгүүлэх модыг харьяа сум дундын ойн ангиар талбай тусгаарлуулах, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор багт хуваарилагдсан модыг багийн ИНХ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэдэд олгохдоо талбай тусгаарласан газраас нэг бүрчлэн тэмдэглэн өгч бэлтгүүлэх, мод бэлтгэлийн явцын бүртгэл мэдээллийг хөтлөн баримтжуулж, мод бэлтгэсэн талбайг цэвэрлүүлэн тухай бүрт нь актаар хүлээн авч стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

3.Мод бэлтгэх гэрээ, эрхийн бичигт заасны дагуу төлбөр тооцоог бүрэн хийж орон нутгийн орлогод ойгоос орох орлогын төлөвлөгөөг хуваарийн дагуу төсөвт төвлөрүүлэхийг татварын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт даалгасугай.

4.Тухайн жилд менежмент төлөвлөгөөний дагуу ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэхийг ойн нөхөрлөлийн ахлагч, ойн мэргэжлийн байгууллагын захирал нарт үүрэг болгосугай.

5.Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойжуулалтын ажлыг зохион байгуулах, комисс томилох, хүлээн авах, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Л.Чимэдцэрэн)-д үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Бямбадалай), Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга) нарт даалгасугай.

ДАРГА



Г. ОДСЭР

Document-Zahiramg

6729010043